

Маргааны товч

Хариуцагч татварын улсын байцаагч нар нь “ЭЖ эрдэнэ майнинг” ХХК-ийн 2019-2022 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн НА-35240000001 дүгээр нөхөн ногдуулалтын акт үйлджээ.

Нэхэмжлэгчээс “...компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Ө.Баянмөнхөөс 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нийт хувьцаагаа 250,000,000 төгрөгөөр О.Түвшинбилэгт шилжүүлж, ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байхад татварын байцаагч нар маргаан бүхий актаар “эцсийн өмчлөгчийг өөрчлөх замаар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эрх шилжүүлсний орлогоос албан татвар суутган авч төсөвт төлөөгүй зөрчил гаргасан” гэж компанийг буруутган Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1.1-ийг баримтлан нийт 112,500,000 төгрөгийн төлбөр (нөхөн татвар, торгууль, алданги) ногдуулсан нь үндэслэлгүй, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.2.2-ийг зөрчсөн. Мөн Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 06 дугаар сарын 12-ны захирамжаар хувьцаа худалдах, худалдан авах гэрээнээс татгалзсаныг нь баталж, хүчингүй болгосон. Н.Баянмөнх ямар нэгэн орлого олоогүй тул татварын актыг хүчингүй болгож өгнө үү” гэж;

хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “... татвар суутган авч, төсөвт төлөөгүй тул нэхэмжлэгчид хуулийн дагуу хариуцлага оногдуулсан. Төлбөрийг бүрэн шилжүүлсэн байдаг тул Ө.Баянмөнхийг орлого олоогүй гэх үндэслэл байхгүй. Иймд нэхэмжлэлийн шаардлага үндэслэлгүй ...” гэх агуулгаар тус тус маргажээ.